

/Тэмдэглэл/

Ан Нэг: Босго алхсан айлынхаа тухай товчхон үгүүлэх нь



Дэлхийн хоёрдугаар дайны /Аугай их эх орны дайн/ ялалтын 70 жилийн ойг тохиолдуулан Алтайн бүгд найрамдах улсын Горно-Алтай хотод таван сарын 7-8-нд зохион байгуулагдах эрдэм шинжилгээний хуралд оролцох урьдчилсан урилгыг бүүр онгорсон 2014 оны намар 10-н сард надад амаар мэдэгдэж билээ.

Түүнээс хойш бүтэн зургаан сарын хугацаа онгорсон болохоор моноох урилгын тухай бараг л 4 мартчихсан явтал 4 сарын эхээр АБНУ-ын холбогдох нохдоос цахим шуудангаар захидал илгээж, 4 мартчихсан сарын 25-ны одор албан ёсны урилга ирүүлэв. Үүнийг дурьдахын учир нь аливаа ажлыг толовлож зохион байгуулна гэдэг нэг хоёр долоо хоног ч юм уу, сайндаа ганц хоёр сарын олно шийдээд бужигнуулчихдаг зүйл биш

байваас сая илүү утга учиртай болох тухайд хэн хүнд санаа огмоор санагдсаных юм.

АА Ингээд 5 сарын 4-ны үүр шоноор хилийн дээс алхахаар мордож, мянган километр замыг 22 цагийн турш туулан, Горний Алтай хотод очив.

Оросын хил рүү орж, Кош-Агачийн районоос цааш 40-50 километр алсалмагц алдарт Чуйн хондий залгаж, байгалийн ер бусын сүрлэг үзэсгэлэнтэй тогтоцыг чимсэнАА битүү ногоон ой модон дундуур урагшлах аж. Хааш л харна битүү ойгоор зай завсаргүй хучигдсан давхар давхар уулс, сүрлэг хавцал, тэрхүү уулс хийгээд АА хавцлын дундуур угалзран мушгирч улмаа толиорон цэнхэртэх Чуй голын хондий дагасан дардан зам алсад хотлоно.

Зам гэдэг ч зам, байгаль гэдэг ч байгаль, замын дагууд аялал жуулчлалын бяцхан хотхонууд, амралтын газрууд ойр ойрхон тааралдана. Тэрээр эко орчин, эко эдийн засаг, экологийн баримжаат хөгжил гэхчлэн ярьж буй энэ үед тэдгээрийг очоод үзчихэд харамсмааргүй, бас байгальтай харьцаж, тэндээс язгуурлаг, эгэл сайхныг мэдэрч эрчим, хэмнэлээ сэлбэж сэргээе гэвэл энэ мэтийг нүдээр үзэж, чихээр сонсон, сэтгэл хийгээд зургаан мэдрэмжээрээ мэдрэхгүйгээр юун тэр тухай сайрхах хэмээсэн тухайн орчныг “шагших” санаа бодол аяндаа л ургаад ирнэ. Уулын салаа нугачаануудаас цэвэр цэнгэг аршаан булгууд ундарч Чуйн гол хийгээд Катун /Хадан/ морнийг тэжээдэг аж.

Энэхэн зуур нэгэн цагт Монголын эзэнт гүрний /Ойрд Монголын/ нутаг асан энэ үзэсгэлэнт газрыг ийнхүү шагшиж, биеийн байцаалтан дээрээ нэгэнтээ хорш улсын хилийн дээс алхсан гэсэн тамга даруулаад, гадаадын иргэний хувиар зорчиж байна гэхэд битүүхэн харамсах сэтгэгдэл оорийн эрхгүй цээжнээс ургаж байсныг нуух юун.

Бид “Ахташ” тосгоны наахна байх хотол даярын шүтлэг шингэж, тахилга оршсон, рашаан уснаас хэдэнтээ залбиран хүртээд, тэндээс холгвйхэн нэгэн “дача” буюу амралтын газарт бууж хоолоод цааш мордов. /бид гэдэг маань тэр зүгт аяны дороо нийлсэн Ховд нутгийн хоёр бизнесмэн “Алтай номадис” компаний захирал Амараа, мон бизнесмэн Энхсайхан, мон хил дээр таарч ганзага нийлсэн Казакстан улсын Павлодор хотын оршин суугч, /Монголын Ховд аймгаас шилжиж очсон/ Болот гуай түүнтэй хамт яваа хоёр хүн гээд бид тавуул юм

/

Рашаан булгийн дэргэдийнх нь саглагар хэсэг ой модыг хадаг яндар, олон онгийн даавуу шуувуугаар нэвсийтэл ньАА даржээ. Хаа газрын аяс байдал, аж амьдралд олзуурхан

тусгаж авууштай зүйлээс гадна орхиж гээмээр ойлгуулж сануулмаар зүйл бишгвй байдгийн нэг нь энэ юм даа гэсэн бодол эзэмдэв.

Тийнхvv үдшийн бүрийтэй зэрэгцээд моноох алдар суут “Чика Тамин”-ий их давааг давж, улмаар шонийн талаас онгорох ахуйд Горно Алтай хотод намайг буулгаад хамт яваа ноход маань цааш ходлов.



Маргааш оглоо нь босмогц Горно-Алтай хотын байгалийн сайхныг дахиад л алмайран гайхав. Хотын дундуур мушгиран урсах Майима голын хондийг дагуулан байгуулсан энэ хотын хоёр талаар, битvv ойгоор хучигдсан уулс хашиж, ийнхvv уулаар хашигдсан хондий дагууд сунаж байралсан хотын сууршил нь уртаашаа хорь гаруй километр орчим үргэлжилэх бол оргоошоо бараг 10 хврэхгvй километр. Майима гол хотын дундуур, дагууд нь нэвт шувт урсаж цааш одох ба хоёр талын уулсын хормой, бэлээр буюу хотын суурьшлын хоёр захаар нь дардан сайхан авто зам дурайна. Хотын товийн харалдаа хойд талд нь Боберген гэх нэрт модот уул дvнхийх ба энэ уулыг хотынхон тодийгvй Алтай даяар шvтдэг тахилгатай уул гэх.

Надтай хамт эрдэм шинжилгээний хурал болон аугаа их ялалтын 70 жилийн ойд оролцохоор Улаанбаатар хотоос Монголын үндэсний их сургуулийн профессор Наваанзоч Х.Цэдэв, мон сургуулийн докторант Д.Монхбат хоёр суудлын галт тэргээр Улаан үд, Новгород, Барнаул, Бийск хотуудаар дамжин 3000 орчим километр урт замыг туулан байж хүрэлцэн ирсэн бөгөөд ийнхүү бидний гурван Монголыг урьсан хурал зохион байгуулах комиссын ноход ч, Горно-Алтай хотод биднийг ирлээ гэж сүйд болон уулзсан АБНУ-ын зохиолчдын холбооны дарга Бедюров Боронтой Янгович тэргүүт зохиолч ноход, мон Алексее Сергеевич Ивашкин нарын сэтгүүлч ноход ч энэ уулыг ихэд хүндэтгэн ярьж, “Бобергений оройгоор үүл суугаад л ирвэл хэдэн одрийн хурын даллага авч байна гэсэн үг дээ” гэгцгээж байсан юм.

Миний хувьд ногоо хоёр нохроосоо нэг одрийн омо очсон болохоор хурлын омо жаал жуул юм сонирхох зав гарав. Шано долоор очиж, хотын баруун хэсэг, Майимынскийн районд нэгэн зочид буудалд хоносон намайг оглоо эрт утасдмагц Барнаул хотод ажлаар оччихоод байсан ноход *маань /Вестник Горно-Алтайска сонины ерөнхий редактор, АБНУ-ын Сэтгүүлчдийн холбооны нэгдүгээр орлогч дарга Алексее Сергеевич*
/

ажлаа яаравчлан дуусгаж, оглоо 7 цаг гээд Горно Алтай руу яаран буцсан ба 10 цаг онгорч байхад ирж авав.

Тэгснээр сонины редакцид зочилж, АБНУ-ын үндэсний телевиз, мон хэд хэдэн сонины редакцитай танилцаж, удирдлагатай нь уулзаж ярилцахын зэрэгцээ Горно-Алтай хотод тэр одор эхлэж байсан АБНУ-ын хотуудын аварга шалгаруулах хол бомбогийн тэмцээний нээлтийн арга хэмжээнд оролцож, *АА* уулын спортын Олон улсын хэмжээний мастер одгоо 83 настай Лилия хэмээх ахмад эмэгтэй тамирчинтай дотносон ярилцах, хамт зургаа татуулах завшаан ч тохиосон юм.



